

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Биологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/34/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Аудитор: Б.Тэгшсүрэн Утас: 51-261740 Цахим хаяг: tegshsurenb@audit.gov.mn Ажу мэргэн аудит ХХК-ийн захирал: Л.Насанбуян Утас: 99093142 Цахим хаяг: Ajumergenaudit.mon@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	15
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	16
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	17
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	18
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	28
4.1 Ерөнхий зүйл	28
4.2 Материаллаг байдал.....	28
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	28
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	28
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	29
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	30
4.5.1 Завсрын аудитын талаар	30
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	30
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	31
5.1 Төлбөрийн акт	31
5.2 Албан шаардлага.....	31
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	33

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АНУ	Америкийн нэгдсэн Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨМӨЗО	Өвөр Монголын Өөртөө Засах Орон
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ШУА	Шинжлэх ухааны академи



“БИОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН”-ИЙН
ЗАХИРАЛ Д.ГАНТУЛГА ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/403
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Биологийн хүрээлэн”-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Шинжлэх ухаан технологийн сан, АПУ ХК, Монголын алт компанитай байгуулсан гэрээний оны эцсээр төлөгдсөн төлбөрүүдийг төрийн санд буцаан төвлөрүүлж, 418,122.5 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Шинжлэх ухааны академийн Биологийн хүрээлэн 2025 онд “Олон улсын эрдэм шинжилгээний хурал” (IBCM-2025), “Амьд ертөнцийн спектр” үзэсгэлэн, “GBIF-ийн анхны сургалт”, “Оюутны анхдугаар биологийн олимпиад”, “Орос Монголын биологийн иж бүрэн экспедицийн 55 жилийн ойн эрдэм шинжилгээний хурал” зэрэг 5 томоохон ажлыг зохион байгуулсан байна.

Тайлант онд дотоод, гадаад хамтын ажиллагааны хүрээнд Шинжлэх ухаан технологийн сангийн захиалгаар хэрэгжүүлж буй 4 төсөл, Олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлж буй 6 төсөл, дотоодын байгууллагуудаас хэрэгжүүлж буй 6, нийт 16 эрдэм шинжилгээ, судалгааны ажлаас нийт 1,361,050.1 мянган төгрөгийн санхүүжилт авч 946,769.1 мянган төгрөгийг холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулсан байна.

Бусад асуудал

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.Наранчимэг

Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,373,647,995.00	1,287,129,108.86
33	АВЛАГА	491,557,987.75	418,122,548.61
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	50,874.29	156,873.60
33300	Татаас, санхүүжилтийн авлага	483,946,349.36	414,281,005.39
33500	Бусад авлага	7,560,764.10	3,684,669.62
33520	Хувь хүмүүсээс авах авлага	7,560,764.10	3,684,669.62
34	УРЬДЧИЛГАА	49,380,000.00	-
34710	Урьдчилгаа тооцоо	49,380,000.00	-
34714	Томилолтын урьдчилгаа	49,380,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	832,710,007.25	869,006,560.25
35300	Бэлэн бүтээгдэхүүн	708,566,782.00	576,993,344.00
35400	Хангамжийн материал	123,903,225.25	291,773,216.25
35410	Бичиг хэргийн материал	7,998,400.00	10,531,210.00
35420	Аж ахуйн материал	28,376,301.00	31,010,257.00
35470	Бусад хангамжийн материал	87,528,524.25	250,231,749.25
35600	Мал амьтад	240,000.00	240,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,033,925,602.11	3,117,812,282.76
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,033,925,602.11	3,117,812,282.76
39200	Биет хөрөнгө	1,944,007,927.38	2,089,939,052.40
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,277,082,763.09	1,277,082,763.09
39202	Хуримтлагдсан элэгдэл	(385,049,019.41)	(449,347,463.21)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,911,009,100.25	1,877,206,144.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	(933,168,248.84)	(680,924,978.52)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	96,681,423.33	94,255,423.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	(40,829,895.07)	(43,381,834.27)
39214	Бусад үндсэн хөрөнгө	31,451,336.30	31,451,336.30
39215	Хуримтлагдсан элэгдэл	(15,661,332.27)	(19,019,239.11)
39217	Ном	2,491,800.00	2,616,900.00
39300	Биет бус хөрөнгө	1,089,917,674.73	1,027,873,230.36
39301	Программ хангамж	2,535,650.00	1,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,077,316.75)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	1,099,890,360.00	1,099,890,360.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(10,431,018.52)	(73,017,129.64)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	4,407,573,597.11	4,404,941,391.62
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	68,707,450.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	68,707,450.00
41300	Өглөг	-	68,707,450.00
41360	Бусад өглөг	-	68,707,450.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	68,707,450.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,407,573,597.11	4,336,233,941.62
51	Засгийн газрын хувь оролцоо	4,407,573,597.11	4,336,233,941.62
51101	Өмч: - төрийн	1,803,663,163.92	1,803,663,163.92
51200	Хуримтлагдсан үр дүн	2,011,809,585.19	1,940,469,929.70
51210	Өмнөх үеийн үр дүн	47,499,139.48	2,011,809,585.19
51220	Тайлант үеийн үр дүн	1,964,310,445.71	(71,339,655.49)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	592,100,848.00	592,100,848.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	4,407,573,597.11	4,404,941,391.62

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар
болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	6,291,091,791.12	5,616,933,799.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,131,720,977.12	5,616,933,799.08
120	Нийтлэг татварын бус орлого	1,131,720,977.12	234,972,265.49
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	806,300,000.00	420,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	420,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	806,300,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	11,680,977.12	234,552,265.49
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	313,740,000.00	-
122	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	-	5,381,961,533.59
1221	Хандив тусламж /дотоод/	-	5,381,961,533.59
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	4,446,885,152.24
122111	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	4,446,885,152.24
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	935,076,381.35
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	60,691,190.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	874,385,191.35
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,159,370,814.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,994,458,200.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,994,458,200.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,164,912,614.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	70,814,378.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	406,548,999.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	687,549,237.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,326,781,345.41	5,688,273,454.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,326,781,345.41	5,688,273,454.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,301,150,269.65	5,473,814,461.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,493,390,346.63	2,898,214,330.77
210101	Үндсэн цалин	1,606,676,542.00	1,605,925,048.72
210102	Нэмэгдэл	601,181,207.63	724,298,156.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	165,970,862.00	367,844,932.42
210104	Урамшуулал	119,561,735.00	178,516,093.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	21,630,100.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	311,533,637.51	351,984,063.48
210201	Тэтгэврийн даатгал	214,925,437.51	252,727,019.48

Биологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	24,151,900.00	26,835,609.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,076,200.00	12,800,107.65
210204	Ажилгүйдлийн даатгал	12,076,200.00	12,554,958.82
210205	Эрүүл мэндийн даатгал	48,303,900.00	47,066,368.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,155,244.38	69,786,918.95
210301	Гэрэл, цахилгаан	47,712,643.03	45,486,318.13
210302	Түлш, халаалт	16,967,413.36	12,902,081.82
210303	Цэвэр, бохир ус	9,475,187.99	11,398,519.00
2104	Хангамж, бараа материалын зардал	64,884,330.00	171,083,372.00
210401	Бичиг хэрэг	10,855,740.00	19,312,448.00
210402	Тээвэр, шатахуун	10,593,860.00	2,655,110.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,364,371.00	1,684,217.00
210404	Ном, хэвлэл	18,517,900.00	135,155,076.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,910,000.00	960,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,642,459.00	11,316,521.00
2105	Нормативт зардал	91,297,996.00	490,095,177.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	90,887,996.00	488,759,177.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	410,000.00	1,336,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	60,558,873.29	31,969,774.92
210601	Багаж, техник, хэрэгсэл	48,234,603.29	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	1,196,489.92
210604	Урсгал засвар	12,324,270.00	30,773,285.00
2107	Томилолт, зочны зардал	386,491,694.00	297,394,750.00
210701	Гадаад албан томилолт	18,279,537.00	55,563,840.00
210702	Дотоод албан томилолт	368,212,157.00	241,830,910.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	357,052,328.32	474,561,121.71
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	350,842,795.32	459,740,472.71
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	7,390,700.00
210807	Газрын төлбөр	769,533.00	2,429,949.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	461,785,819.52	688,724,952.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,430,050.00	4,812,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	63,860,000.00	187,374,568.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	389,495,769.52	496,537,584.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,631,075.76	214,458,992.90
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	171,276,371.66
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	171,276,371.66
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	171,276,371.66
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	165,536,441.09
2131122	Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	420,000.00
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	5,319,930.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,711,700.00	43,182,621.24

Биологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,711,700.00	3,900,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	37,782,621.24
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,919,375.76	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,816,212.15	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,103,163.61	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	<u>1,964,310,445.71</u>	<u>(71,339,655.49)</u>
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	<u>1,964,310,445.71</u>	<u>(71,339,655.49)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	5,545,524,763.41	5,870,203,977.43
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	5,870,203,977.43
120	Нийтлэг татварын бус орлого	-	420,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	420,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	420,000.00
122	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	-	5,869,783,977.43
1221	Хандив тусламж /дотоод/	-	5,869,783,977.43
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	4,930,831,501.60
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	4,446,885,152.24
122114	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох өмнөх оны төвлөрүүлэх	-	483,946,349.36
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	938,952,475.83
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	60,691,190.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	878,261,285.83
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,545,524,763.41	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,994,458,200.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,994,458,200.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,551,066,563.41	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	70,814,378.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	568,408,101.41	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	911,844,084.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,884,623,721.11	5,524,331,977.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,884,623,721.11	5,524,331,977.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,375,046,295.99	4,895,591,979.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,489,843,968.63	2,898,214,330.77
210101	Үндсэн цалин	1,603,130,164.00	1,605,925,048.72
210102	Нэмэгдэл	601,181,207.63	724,298,156.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	165,970,862.00	367,844,932.42
210104	Урамшуулал	119,561,735.00	178,516,093.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	21,630,100.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	311,684,280.34	352,090,062.79
210201	Тэтгэврийн даатгал	215,076,080.34	252,833,018.79
210202	Тэтгэмжийн даатгал	24,151,900.00	26,835,609.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,076,200.00	12,800,107.65
210204	Ажилгүйдлийн даатгал	12,076,200.00	12,554,958.82
210205	Эрүүл мэндийн даатгал	48,303,900.00	47,066,368.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,155,244.38	69,786,918.95
210301	Гэрэл, цахилгаан	47,712,643.03	45,486,318.13
210302	Түлш, халаалт	16,967,413.36	12,902,081.82
210303	Цэвэр, бохир ус	9,475,187.99	11,398,519.00
2104	Хангамж, бараа материалын зардал	122,967,425.00	180,807,586.00
210401	Бичиг хэрэг	10,994,960.00	11,526,406.00
210402	Тээвэр, шатахуун	5,105,000.00	2,655,110.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,364,371.00	1,684,217.00
210404	Ном, хэвлэл	84,357,380.00	148,852,332.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,910,000.00	960,000.00

Биологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,235,714.00	15,129,521.00
2105	Нормативт зардал	289,021,408.00	386,183,091.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	284,213,508.00	383,527,091.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,807,900.00	2,656,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	78,278,978.40	49,259,749.92
210601	Багаж, техник, хэрэгсэл	55,286,378.40	24,101,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,572,900.00	1,180,999.92
210604	Урсгал засвар	21,419,700.00	23,976,850.00
2107	Томилолт, зочны зардал	441,360,554.00	248,014,750.00
210701	Гадаад албан томилолт	18,279,537.00	55,563,840.00
210702	Дотоод албан томилолт	423,081,017.00	192,450,910.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	502,874,437.24	533,197,671.71
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	494,988,704.24	517,987,022.71
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,676,200.00	5,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	7,780,700.00
210807	Газрын төлбөр	769,533.00	2,429,949.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,860,000.00	178,037,818.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	14,992,455.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	64,860,000.00	163,045,363.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	509,577,425.12	628,739,998.29
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	585,557,377.05
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	585,557,377.05
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	585,557,377.05
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	165,536,441.09
2131122	Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	420,000.00
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	5,319,930.57
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	414,281,005.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,711,700.00	43,182,621.24
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,711,700.00	3,900,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	37,782,621.24
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	502,865,725.12	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,816,212.15	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	488,049,512.97	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	660,901,042.30	345,872,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	660,901,042.30	345,872,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	660,901,042.30	345,872,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	660,901,042.30	345,872,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	660,901,042.30	345,872,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(660,901,042.30)	(345,872,000.00)
XII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
XIII	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
XIV	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,803,663,163.92	592,100,848.00	47,499,139.48	2,443,263,151.40
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,803,663,163.92	592,100,848.00	47,499,139.48	2,443,263,151.40
3	Тайлант үеийн үр дүн	-	-	1,964,310,445.71	1,964,310,445.71
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,803,663,163.92	592,100,848.00	2,011,809,585.19	4,407,573,597.11
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,803,663,163.92	592,100,848.00	2,011,809,585.19	4,407,573,597.11
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(71,339,655.49)	(71,339,655.49)
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,803,663,163.92	592,100,848.00	1,940,469,929.70	4,336,233,941.62

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,536,519,000.00	4,281,348,711.15	213,709,111.80	94.9
12	Татварын бус орлого	4,536,519,000.00	4,281,348,711.15	213,709,111.80	94.9
122	Тусламжийн орлого	4,536,519,000.00	4,281,348,711.15	213,709,111.80	94.9
122005	Төсвөөс санхүүжих	4,536,519,000.00	4,281,348,711.15	213,709,111.80	94.9
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,536,519,000.00	4,281,348,711.15	255,170,288.85	94.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,536,519,000.00	4,281,348,711.15	255,170,288.85	94.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,461,670,900.00	4,238,166,089.91	223,504,810.09	95.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,012,594,000.00	2,841,055,173.54	171,538,826.46	94.3
210101	Үндсэн цалин	1,465,688,600.00	1,570,395,991.72	(104,707,391.72)	107.1
210102	Нэмэгдэл	941,377,000.00	724,298,156.40	217,078,843.60	76.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	363,088,300.00	367,844,932.42	(4,756,632.42)	101.3
210104	Урамшуулал	242,440,100.00	178,516,093.00	63,924,007.00	73.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	378,327,900.00	347,063,840.79	31,264,059.21	91.7
210201	Тэтгэврийн даатгал	249,923,200.00	247,806,796.79	2,116,403.21	99.2
210202	Тэтгэмжийн даатгал	32,144,900.00	26,835,609.40	5,309,290.60	83.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,992,400.00	12,800,107.65	3,192,292.35	80.0
210204	Ажилгүйдлийн даатгал	16,052,700.00	12,554,958.82	3,497,741.18	78.2
210205	Эрүүл мэндийн даатгал	64,214,700.00	47,066,368.13	17,148,331.87	73.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,875,000.00	69,786,918.95	3,088,081.05	95.8
210301	Гэрэл, цахилгаан	44,791,400.00	45,486,318.13	(694,918.13)	101.6
210302	Түлш, халаалт	16,917,100.00	12,902,081.82	4,015,018.18	76.3
210303	Цэвэр, бохир ус	11,166,500.00	11,398,519.00	(232,019.00)	102.1
2104	Хангамж, бараа материалын зардал	121,980,700.00	121,980,671.00	29.00	100.0
210401	Бичиг хэрэг	3,379,300.00	3,379,340.00	(40.00)	100.0
210402	Тээвэр, шатахуун	2,655,100.00	2,655,110.00	(10.00)	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,811,000.00	1,684,217.00	126,783.00	93.0
210404	Ном, хэвлэл	103,292,500.00	103,292,446.00	54.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,292,700.00	960,000.00	332,700.00	74.3
2105	Нормативт зардал	109,399,600.00	109,399,530.00	70.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	106,744,500.00	106,743,530.00	970.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,655,100.00	2,656,000.00	(900.00)	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	341,172,900.00	339,501,149.92	1,671,750.08	99.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	310,177,300.00	309,843,300.00	334,000.00	99.9

**Биологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210602	Тавилга	4,500,000.00	4,500,000.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,513,900.00	1,180,999.92	1,332,900.08	47.0
210604	Урсгал засвар	23,981,700.00	23,976,850.00	4,850.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	37,416,000.00	36,664,000.00	752,000.00	98.0
210702	Дотоод албан томилолт	37,416,000.00	36,664,000.00	752,000.00	98.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	305,904,800.00	290,818,150.71	15,086,649.29	95.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	287,347,700.00	277,552,001.71	9,795,698.29	96.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	537,500.00	-	537,500.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	537,500.00	-	537,500.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,089,300.00	5,836,200.00	2,253,100.00	72.1
210807	Газрын төлбөр	4,392,800.00	2,429,949.00	1,962,851.00	55.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	82,000,000.00	81,896,655.00	103,345.00	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,000,000.00	14,992,455.00	7,545.00	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	67,000,000.00	66,904,200.00	95,800.00	99.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	74,848,100.00	43,182,621.24	31,665,478.76	57.7
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,334,400.00	3,900,000.00	3,434,400.00	53.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	66,013,700.00	37,782,621.24	28,231,078.76	57.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	175	175		
61	Байгууллагын тоо	1	1	-	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	86	86	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	78	78	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	7	7	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	86	86	-	100.0
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	79	79	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	7	-	100.0
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	2	2	-	100.0
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	2	2	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		1,422,898,825.19
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		1,422,898,825.19
122	Тусламжийн орлого		1,422,898,825.19
1221	Хандив тусламж /дотоод/		1,422,898,825.19
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,422,898,825.19
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан		232,391,427.22
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,190,507,397.22
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,008,617,819.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,008,617,819.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,008,617,819.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	57,159,157.23
210101	Үндсэн цалин	-	35,529,057.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	21,630,100.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	5,026,222.00
210201	Тэтгэврийн даатгал	-	5,026,222.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	58,952,015.00
210401	Бичиг хэрэг	-	8,147,066.00
210404	Ном, хэвлэл	-	45,684,986.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	5,119,963.00
2105	Нормативт зардал	-	276,783,561.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	276,783,561.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	55,505,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	55,505,500.00
2107	Томилолт, зочны зардал	-	211,350,750.00
210701	Гадаад албан томилолт	-	55,563,840.00
210702	Дотоод албан томилолт	-	155,786,910.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	242,379,521.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	240,435,021.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,944,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	96,141,163.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	96,141,163.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	5,319,930.57
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,319,930.57
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,319,930.57
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		414,281,005.39
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		(414,281,005.39)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт		(414,281,005.39)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

ШУА-ийн Биологийн хүрээлэн эрхэм зорилгоо “Монгол орны амьтны аймаг, бичил биетний олон янз байдлыг хадгалах, нөөц баялгийг өнөө ба ирээдүйн эрх ашигт нийцүүлэн зохистой ашиглах, хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох экосистемийн тэнцвэртэй байдлыг хангахад чиглэсэн инновац, шинэ мэдлэг буй болгох суурь болон хавсарга судалгааг хослуулан хөгжүүлж монгол улсын тогтвортой хөгжилд бодит хувь нэмэр оруулахад оршино” гэж тодорхойлсон байна.

Эрхэм зорилгын хүрээнд Монгол орны амьтны аймаг, бичил биетний олон янз байдлыг хадгалах, экологи биологи онцлогийг эс, эд, бодгаль, популяцийн төвшинд уламжлалт болон орчин үеийн молекул-биологийн онолын суурь судалгааны аргаар явуулж, биологийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн үйл ажиллагааг явуулж байна.

Мөн Монгол орны биологийн олон янз байдал, түүний бүрэлдэхүүн хэсэг амьтны аймаг, бичил биетний биологи, экологи, генетик онцлог, хавдрын эсийн үржлийг дарангуйлагч бодисыг эмийн ургамлаас ялган цэвэршүүлэх, хавдар өвчний молекул механизм, генетик шалтгааныг тогтоох, шим мандлын хувьсал түүний амьдралыг тэтгэн буй системийг хамгаалах ач холбогдол, зүй тогтлыг судлан илрүүлж, биологийн нөөц баялгийг хамгаалах, тогтвортой ашиглах, үндэслэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний технологи бий болгох чиглэлээр эрдэм шинжилгээ, туршилт судалгааны ажлыг гүйцэтгэж байна.

Тайлант онд 3 чиглэлийн хүрээнд үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн байна. Үүнд:

- Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ
- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ
- Хуулиар олгосон тусгайлсан болон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Биологийн хүрээлэн нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Инновацын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант хугацаанд хүрээлэнгийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Сангийн сайдын 2025 оны 01 сарын 03-ны өдрийн “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” А/3 дугаар тушаал;

Хүрээлэнгийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тайлант онд тус хүрээлэнд Шинжлэх ухааны академийн Тэргүүлэгчдийн газрын даргын баталсан удирдамжаар хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагаа гэсэн 2 чиглэлээр дотоод хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Биологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Монгол улсын тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны А/113 дугаар тушаалаар баталсан байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Биологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,632.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	491,558.0	418,122.5	(73,435.5)
Урьдчилгаа	49,380.0	-	(49,380.0)
Бараа материал	832,710.0	869,006.5	36,296.5
Үндсэн хөрөнгө	3,033,925.6	3,117,812.3	83,886.7
Нийт хөрөнгө	4,407,573.6	4,404,941.3	(2,632.3)
Богино хугацаат өр төлбөр	-	68,707.4	68,707.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,407,573.6	4,336,233.9	(71,339.7)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,407,573.6	4,404,941.3	(2,632.3)

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснууд байна. Үүнд:

Дансны авлага 418,122.5 мянган төгрөг болж өмнөх оноос 73,435.5 мянган төгрөгөөр буурсан нь нэмэлт санхүүжилтийн дансанд өмнөх оны эцсээр орж ирсэн эрдэм шинжилгээ судалгааны ажлын санхүүжилтийн орлогыг төсөвт төвлөрүүлэн авлагаар бүртгэсэн байсан 491,558.0 мянган төгрөгийн авлага барагдсан. Тайлант онд Шинжлэх ухаан технологийн сан, АПУ ХК, Монголын алт компанитай байгуулсан гэрээний тооцоо оны эцсээр орж ирснийг төрийн санд САГ-2026/34/НА-СТА-ТШЗ

буцаан төвлөрүүлж, 414,281.0 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл өмнөх оноос 49,380.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны урьдчилгаа дансанд бүртгэлтэй байсан тооцоог дуусгасантай холбоотой байна.

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 36,296.5 мянган төгрөгөөр өссөн нь шавж судлалын үзмэрийн санг баяжуулах 120,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий эрвээхэйн хатаамлын үзмэр эталон бэлтгэсэн, төслийн судалгаа шинжилгээний ажилд шаардлагатай урвалж бодис, бусад хангамжийн материал худалдан авсан нь голлон нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 3,117,812.3 болж 83,886.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 271,422.5 мянган төгрөг, шууд худалдан авах аргаар 78,749.5 мянган төгрөг, нийт 350,172.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авснаас голлон нөлөөлсөн. Мөн ТӨБЗГ-ын 2025 оны 297, 732 дугаар тогтоолуудаар элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой 192 нэр төрлийн 550,957.7 мянган төгрөгийн өртөг бүхий хөрөнгийн үнийг 230,252.3 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон, ТӨБЗГ-ын 309, 862 дугаар тогтоолуудаар элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 88 нэр төрлийн 67,106.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан, тайлант хугацаанд 496,537.6 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцож бүртгэсэн зэргээс буурсан байна. Үүнээс,

Биет бус хөрөнгө буюу программ хангамжийн дансанд 2,535.6 мянган төгрөгийн өртөг бүхий Хас эрин орчил ХХК-ийн Dynamic 1.0 санхүүгийн программ, 293,590.4 мянган төгрөгийн газар эзэмших эрх, 1014,440.8 мянган төгрөгийн өртөг бүхий 15 төрлийн патент бүртгэлтэй бөгөөд санхүүгийн программ хөгжүүлэлт, засвар үйлчилгээний төлбөрт жилд 440.0 мянган төгрөг төлж байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх оноос 68,707.4 мянган төгрөгөөр өссөн нь гэрээний дагуу бусдаар гүйцэтгүүлсэн ажлуудын үлдэгдэл төлбөрүүдийг санхүүжилтийн эрх үүсээгүйн улмаас өглөгөөр бүртгэж тайлагнасанатай холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 71,339.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус хүрээлэнгийн 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,873,419.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлсний зардлын төсвийг 336,900.0 мянган төгрөгөөр бууруулж 4,536,519.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээний санхүүжилт 4,536,519.0 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,536,519.0 мянган төгрөгийг баталснаас гүйцэтгэлээр 4,446,885.1 мянган төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс авч, 165,956.4 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,281,348.7 мянган төгрөг буюу 94.4 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 171,538.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 31,264.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 3,088.1 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 1,671.8 мянган төгрөг, томилолт зочны зардлыг 752.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 5,291.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 103.3 мянган төгрөг, харуул хамгаалалтын зардлыг 3,294.7 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 31,665.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөрийн зардлыг 6,501.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71805	Шинжлэх ухаан, технологи	4,536,519.0	4,281,348.7	255,170.3	94.4
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	4,174,323.2	3,960,614.1	213,709.1	94.9
80219	Харуул, хамгаалалтын зардал	41,806.8	38,512.1	3,294.7	92.1
80202	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	74,848.1	43,182.6	31,665.5	57.7
81569	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	245,540.9	239,039.9	6,501.0	97.4

Тайлант онд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд урсгал үйл ажиллагааны төсвөөс 239,039.9 мянган төгрөг зарцуулсан ба үүнээс шавж судлалын үзмэрийн санг баяжуулах эрвээхэйн хатаамлын үзмэр эталон бэлтгэхэд 120,000.0 мянган төгрөг, гэрээний үндсэн дээр бусдаар гүйцэтгүүлсэн дээж шинжилгээний зардалд 119,039.9 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2025 оны санхүүгийн тайлангийн аудитын үндсэн чиглэлийн дагуу хийсэн судалгааны үр дүнгийн талаар:

1. Тус хүрээлэнгийн бүтэц орон тоог Шинжлэх ухааны академийн тэргүүлэгчдийн хурлын 2025 оны 04 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд нийт 95 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулахаар батлагдсан, 2025 онд албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

2. Тус хүрээлэн нь ажилчдадаа өдөрт 17.0 мянган төгрөгийн хоолны, 0.5 мянган төгрөгийн унааны хөнгөлөлт олгож, тайлант онд дээрх зардалд нийт 367,844.9 мянган төгрөг зарцуулсан бөгөөд өмнөх оноос 201,865.1 мянган төгрөг буюу 121.6 хувиар нэмэгдсэн байна.

3. Тайлант онд тус хүрээлэн нь нэмэлт санхүүжилтийн данснаас гадаад томилолтын зардалд нийт 55,563.8 мянган төгрөгийг дараах арга хэмжээнд зарцуулсан байна Үүнд:

- ОХУ-ын Саранск хотод зохион байгуулагдсан “Сарьсан далавчтан шавж судлалын Евразийн 6-р Симпозиум”-д оролцож илтгэл хэлэлцүүлэх, ОХУ-ын Алс Дорнодын хуурай газрын биологийн олон янз байдлын судалгааны төвд ажиллах;
 - Тайвань Улсын Academia Sinica Биологи химийн хүрээлэнд “Экзополимер нийлэгжүүлэгч бичил биетний олон янз байдал, хөрсний эрүүл төлөв байдалд гүйцэтгэх үүргийг Монгол орны хур тунадасны градиентээс хамааруулж судлах нь” төслийн хүрээнд хөрсний бичил биетний гаралтай экзополисахаридын химийн шинж чанарыг судлах туршилтууд явуулах, хөрснөөс ялгасан бичил биетний ангилал зүйг тогтоох, үр дүнг боловсруулах ажлаар эрдэм шинжилгээний 2 ажилтан 35 хоног ажиллах;
 - БНХАУ-ын Амьтан судлалын хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлж буй төслийн явцыг хэлэлцэн, ӨМӨЗО-ны бэлчээр судлалын хүрээлэнтэй дундын лаборатори байгуулах;
 - American Society for Microbiology нийгэмлэгээс жил бүр АНУ-ын Лос Анжелес хотод зохион байгуулдаг микробиологийн шинжлэх ухааны “ASM Microbe 2025” олон улсын их хуралд ханан илтгэл хэлэлцүүлэх.
4. Биологийн хүрээлэн нь тайлант онд дараах сургалтуудад нийт 154,045.3 мянган төгрөг зарцуулсан бөгөөд үүнээс 57,904.2 мянган төгрөгийг урсгал зардлын төсвөөс, 96,141.1 мянган төгрөгийг нэмэлт төсвөөс тус тус зарцуулсан байна. Үүнд:
- The Alliance of National and International Science Organizations for the Belt and Road Regions (ANSO) байгууллагаас “Экзополимер нийлэгжүүлэгч бичил биетний олон янз байдал, хөрсний эрүүл төлөв байдалд гүйцэтгэх үүргийг Монгол орны хур тунадасны градиентээс хамааруулж судлах нь” төслийн даалгаварт тусгагдсаны дагуу “Microbes in Action: Addressing Global Challenges 2025” сэдэвт эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан;
 - “Монгол Оросын Хамтарсан Биологийн Иж Бүрэн Экспедицийн 55 жилийн ойн эрдэм шинжилгээний хурал”-ыг 2025 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр Чингис Хааны Үндэсний Музейд зохион байгуулсан байна. Тус хуралд ОХУ болон манай орны 120 гаруй эрдэмтэн судлаачид Монгол орны ургамал, амьтны аймаг, экосистемийн талаар хийгдсэн нийт 23 илтгэлийг хэлэлцүүлсэн. Хурлын зохион байгуулалтын ажлын хүрээнд нийт 56 илтгэлийн хураангуйг эмхэтгэн веб хуудас үүсгэн байршуулж, өгүүллийн эмхэтгэлийг 103 ш хэвлүүлсэн байна. Мөн хурлын илтгэлийн хураангуйг Биологийн хүрээлэнгийн бүтээлийн тусгай дугаар хэлбэрээр Монгол, Орос болон Англи хэл дээр орчуулж, эмхэтгэн гаргасан.
 - “IVCM 2025” Олон Улсын хурлын хүрээнд биологийн олон янз байдал, бичил биетэн, молекул биологи, биотехнологийн чиглэлээр хийгдсэн судалгааны ажлуудыг хэлэлцэж, Монгол болон гадаадын эрдэмтэн, судлаачдын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэсэн уулзалт, хэлэлцүүлгүүд зохион байгуулсан. Тус хурлыг биологийн шинжлэх ухааны салбарын орчин үеийн судалгааны үр дүнг олон улсын түвшинд хэлэлцэх, туршлага солилцох, эрдэм шинжилгээний хамтын ажиллагааг өргөжүүлэх, залуу судлаачдыг дэмжих, судалгааны үр дүнг тогтвортой хөгжил, байгаль хамгаалал, бодлого боловсруулахад ашиглах боломжийг тодорхойлох зорилгоор зохион байгуулсан болно.
5. Тайлант онд хэвлэл, мэдээлэлтэй холбоотой 3 төрлийн үйл ажиллагаанд нийт 20,564.3 мянган төгрөг зарцуулсан байна. Үүнд:
- ШУА, “Тогтвортой хөгжлийн төлөө сэтгүүлчдийн клуб”-тэй байгуулсан “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийн хүрээнд “Хүрээлэн 2025” гэрээ байгуулж, ШУА болон түүний харьяа хүрээлэнгүүдийн эрдэмтэн судлаачдын эрдэм шинжилгээ, судалгааны

ажлын үр дүн, шинэ бүтээл, инновацыг түгээн дэлгэрүүлэх, шинжлэх ухааны салбарын ач холбогдлыг олон нийтэд таниулан мэдүүлж, хүүхэд, залуучуудыг бага наснаас нь шинжлэх ухааны хөгжлийн үйл хэрэгт идэвхтэй оролцдог болгон төлөвшүүлэх зорилгын хүрээнд ТВ контент бүтээх үйл ажиллагаанд 2,000.0 мянган төгрөг зарцуулсан;

- Springer Natureийн Atlantis Press олон улсын сэтгүүлд бүтээл хэвлүүлэх эрх авах Atlantis press "Proceedings agreement" гэрээний төлбөрт 14,675.3 мянган төгрөг зарцуулсан. Тухайн сэтгүүлд нийтлэгдсэн хурлын бүтээлүүд нь хүлээн зөвшөөрөгдсөн суурь мэдээллийн санд бүртгэгддэг (тухайлбал: CPCI, CNKI, Google Scholar, Scopus гэх мэт);
- Биологийн хүрээлэнгийн олон улсын хурлын "IBCM conference website" хөгжүүлэлт, бэлэн загвар худалдан авалт, сайжруулалт, веб байршуулалт, домэйн нэр холболт, тохиргоо хийх зэрэг зардалд нийт 3,889.0 мянган төгрөг зарцуулсан.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 232,391.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,190,507.4 мянган төгрөг, нийт 1,422,898.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 57,159.2 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 5,026.2 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 58,952.0 мянган төгрөг, нормативт зардалд 276,783.5 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 55,505.5 мянган төгрөг, томилот, зочны зардалд 211,350.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 242,379.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 96,141.2 мянган төгрөг, нийт 1,003,297.9 мянган төгрөгийг зарцуулж, 419,600.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлсэн орлогоос шинжлэх ухаан технологийн сангийн захиалгаар хэрэгжүүлэх "Монгол орны бэлчээр болон газар тариалангийн бууцаар бордсон хөрсөн дэх антибиотик тэсвэрлэх чадамжийг илрүүлэх нь" төслийн ажил эхлээгүй байгаа тул уг төслийн 260,162.1 мянган төгрөг, МАК компанийн "Хөхөлзөхийн говь" төслийн сүүлийн санхүүжилт 51,554.3 мянган төгрөг, АПУ ХК-ийн "Эмийн ургамлаас сертуины бүлгийн уургуудыг идэвхжүүлэгч биологийн идэвхт бодис тодорхойлох, тэдгээрийг ашиглан хүнсний бүтээгдэхүүн гаргах" судалгааны ажлын 37,162.7 мянган төгрөг, нийт 414,281.0 мянган төгрөгийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын санхүүжилтийг Сангийн яамтай тооцоо нийлж, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд суурь судалгааны төсөл 2, олон улсын хамтарсан төсөл 4, грант төсөл 2, улсын захиалгат төсөл 1, Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн судалгааны үндсэн чиглэлийг

Биологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

хэрэгжүүлэх 1, Цөм технологийн төсөл 1, нийт 11 төслийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Тайлант онд хэрэгжүүлсэн нийт 16 төслөөс 9 төслийн ажил амжилттай хэрэгжиж дууссан, 2026-2027 онд хэрэгжиж дуусах “Элэгний хавдрын өвөрмөц биомаркер илрүүлэх судалгаа”, “Монгол бөхөн болон аргаль хонины хамгааллын геномиксийн судалгаа”, “Ховор эмийн ургамлын хоёрдогч метаболитын бионийлэгжлийн генийн судалгаа”, “Монгол алтай нурууны шавжийн биологийн олон янз байдал, хамгаалал”, “Монгол орны бэлчээр болон газар тариалангийн бууцаар бордсон хөрсний антибиотик тэсвэрлэх чадамжийг илрүүлэх нь”, “Эмийн ургамлаас сертуины бүлгийн уургуудыг идэвхжүүлэгч биологийн идэвхт бодис тодорхойлох, тэдгээрийг ашиглан хүнсний бүтээгдэхүүн гаргах судалгаа”, “Biodiversity Priority Plant Propagation Research Service” зэрэг төслийн ажил үргэлжилж байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

Д/д	Төслийн нэр	Төслийн зорилго, хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц, хүрсэн үр дүн	Хугацаа	Нийт санхүүжилт	Үүнээс: тайлант хугацааны санхүүжилт
Шинжлэх ухааны технологийн сангаас санхүүжүүлсэн эрдэм шинжилгээ судалгааны ажил						
1	Элэгний хавдрын өвөрмөц биомаркер илрүүлэх судалгаа	Элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх биомаркер илрүүлэх, хорт хавдрын эмчилгээг шинэ шатанд гаргах, эмнэл зүйн практик дахь хэрэглээг өргөжүүлэх	Япон улсын Каназавагийн их сургуультай хамтран генийн экспрессийн судалгааг хийж Монгол хүн амын дунд элэгний хавдрын өвөрмөц биомаркер болгон хөгжүүлэх боломжтой NEU4 болон RAP2C уургуудыг тодорхойлсон	2024 - 2026	60,000.0	10,000.0
2	Монгол бөхөн болон аргаль хонины хамгааллын геномиксийн судалгаа	Монгол орны нэн ховор статустай Монгол бөхөн болон аргаль хонины хамгааллын менежментийг зөв оновчтой хийх шинжлэх ухааны үндэслэлийг гаргах нь төслийн үндсэн зорилго болно.	Судалгааны ажлын аргазүйг хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөр батлуулсан. 2025 оны 6 сард Говь-Алтай, Ховд аймгийн нутгаар хээрийн судалгааг зохион байгуулж нийт 11 монгол бөхөнгийн генетикийн дээж цуглуулсан.	2024 - 2026	59,063.0	15,000.0
3	Ховор эмийн ургамлын хоёрдогч метаболитын бионийлэгжлийн генийн судалгаа	Үнэгэн сүүлхэй лидэр, Байгалийн гүүн хөх, Дэрэвгэр жиргэрүү ургамлыг <i>in vitro</i> орчинд нөхөн төлжүүлэх, хоёрдогч метаболитын нийлэгжлийн замыг судалж сонгогдсон генүүдэд экспрессийн судалгааг байгалийн, таримал болон <i>in vitro</i> дээжид харьцуулан судлах.	Судалгааны ажил үргэлжилж байна	2024 - 2026	58,740.0	15,740.0

**Биологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

4	“Инвазив бус аргаар ургийн гажгийг дижитал полимеразийн гинжин урвал (ПГУ) ашиглан илрүүлэх нь”	Ургийн 21, 18, 13-р хромосомын трисоми өөрчлөлтийг дижитал ПГУ ашиглан, инвазив бус аргаар илрүүлэх, цаашид тус аргыг Монгол улсад нутагшуулах судалгааг хийж гүйцэтгэх	Нийт 43 дээжид хийсэн судалгааны үр дүнд үндэслэн хүн амын дундах шинжилгээний хромосомын харьцааны суурь утга болон босго утгыг амжилттай тодорхойлсон.	2023 - 2025	120,000.0	19,951.2
Олон Улсын байгууллагын санхүүжилтээр хийгдсэн судалгааны ажил						
5	Хөрсний экзополимерийн бичил биетний олон янз байдал, хөрсний эрүүл төлөв байдалд гүйцэтгэх үүргийг Монгол орны хур тунадасны градиентаас хамааруулж судлах нь”	Монгол орны ойт хээр, хээр, цөлөрхөг хээр, цөлийн бүсийн хөрсний бичил биетний ялгаруулдаг экзополимерийг ашиглан хөрсний тоос дарах боломжийн судалгааг хийж гүйцэтгэсэн. Монгол орны хөрсний чанарыг иж бүрэн үнэлсэн судалгаа ховор бөгөөд хөрсний чанар нь биологийн шинж чанартай хэрхэн уялддагийг экосистемийн түвшинд судалж хамгийн бага өгөгдлийн багц (MDS) арга дээр үндэслэн байгалийн хөрсний чанарын байдлыг үнэлэх	Хөрсний бактери бичил биетний трофик хэлхээнд хамгийн чухал үүрэгтэй боловч орчны өөрчлөлтөд хамгийн эмзэг байгаа нь тогтоогдов.	2022 - 2025	534,750.0	143,326.6
6	Монгол алтай нурууны шавжийн биологийн олон янз байдал, хамгаалал	Монгол Алтай нурууны өндөр уулын өвөрмөц экосистемд тархан амьдрах шавжийн биологийн төрөл зүйлийг илрүүлэн судлах, биологийн олон янз байдлыг нөхцөлдүүлж буй өвөрмөц амьдрах орчныг тодорхойлох, энэ бүс нутгийн тусгай хамгаалалттай газруудын эндемик, ховор зүйлийн шавжийн биологийн төрөл зүйлийг үнэлэх	Сутай Хайрхан уулын Хөшөөт голын усны амьдрах орчинд 2 хүрээ, 3 анги, 8 баг, 13 овогт хамаарах 14 төрлийн ёроолын макро сээр нуруугүйтэн тархан амьдарч байгаа бөгөөд тус голын ЕРТ шавжийн бүрдлийг судалж үзэхэд <i>Apataniana</i> sp., <i>Isoperla</i> sp., <i>Arcynopteryx</i> sp. зэрэг зүйлүүд маш цөөн тоогоор тохиолдож байгааг тогтоосон.	2024 - 2026	174,043.3	41,981.0
7	“Монгол орны бэлчээр болон газар тариалангийн бууцаар бордсон хөрсний антибиотик тэсвэрлэх чадамжийг илрүүлэх нь”	Төслийн хүрээнд Монгол орны газар тариалан, бэлчээрийн хөрсөнд агуулагдах зарим антибиотикт тэсвэртэй бичил биетэн болон антибиотикт тэсвэртэй генийг тодорхойлж, малын бууц нь газар тариалан болон бэлчээрийн хөрсний найрлага болон микроорганизмд хэрхэн нөлөөлж байгааг судалж, үнэлэх зорилготой.	Дархан, Сэлэнгэ болон Улаанбаатар хот орчмын нутаг дэвсгэрээс тус судалгаанд ашиглагдах хөрсний дээжийг 37 цэгээс цуглуулан авч, зохих нөхцөлийн дагуу тээвэрлэн лабораторид авчирч -80°C хөргөгчид хадгалж байна. Тус дээжийг ашиглан микроорганизм ялгах туршилтын ажил явагдаж байна.	2025 - 2027	513,360.0	260,162.1

Биологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

8	Монгол орны баруун бүсийн Реликт цахлайн үржлийн экологи, хамгааллын хэрэгцээ” 2025 он.	Реликт цахлайн үүрлэлт, үржлийн амжилтын судалгааг хийж, цаашид тогтвортой ажиглалт мониторинг хийх газрыг сонгох, судалгааны мэдээллийг нэгтгэх	Судалгааны явцад Монгол орны баруун бүсийн нийт 25-н нуурыг шалгасан бөгөөд үүнээс Говь-Алтай аймгийн Ихэс нуур, Увс нуур нь Реликт цахлайн үржлийн популяцийн хамгийн чухал ач холбогдолтой нуур болохыг тогтоосон.	2025	28,550.0	28,550.0
9	Цэн тогоруу <i>Antigone vipio</i> , хонин тоодог OTIS TARDA DYBOWSKII шувууны мониторинг судалгаа, хийх ажил гүйцэтгэх гэрээ	Онон-Балжийн БЦГ түүний орчны бүсэд цэн тогоруу болон хонин тоодгийн тоо толгой, үрждэг, шүхэрлэдэг, чухал амьдрах орчин, үржлийн амжилтыг үнэлэх, мониторинг хийх, цэн тогорууны амьдрах орчныг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагатай газрыг тодорхойлох,	Онон-Балжийн байгалийн цогцолборт газар төслийн хүрээнд цэн тогоруу, хонин тоодог болон бусад шувуудын тархац, тоо толгой, үржлийн амжилт, нүүдэл, амьдрах орчны төлөв байдлын улирлын мониторинг судалгааг гүйцэтгэсэн.	2025	47,690.0	32,540.0
10	Монгол орны махчин шувуудын судалгаа, хамгааллын менежмент” идлэг шонхорын 10 бодгалийн гуужсан өдний генотип тодорхойлох”	Төв аймгийн Баян сумд байршуулсан хиймэл үүрнүүдээс Идлэг Шонхорын гуужсан өдийг цуглуулан, үүр сэлгэлтийг судлах зорилгоор тухайн өднөөс нуклейн хүчлийг ялгаж, 10 микросателит локусыг ПГУ-ын аргаар олшруулан, капилляр электрофорезоор шалгаж идлэг Шонхорын үүр сэлгэлтийг илрүүлэх, бодгалийг тодорхойлоход инвазив бус арга буюу гуужсан өдийг ашиглах боломжийг үнэлэх	Төв аймгийн Баян сумын нутагт байрлуулсан хиймэл үүрнээс 5 үүрийг сонгож тухайн үүрт цугларсан гуужсан өднүүдийг (нийт 10) судалгаанд ашигласан. Өдний угны үзүүрээс 0.5см хэсгийг таслан авч сайтар жижиглэн хэрчиж цомгоор ялгахад бэлтгэсэн. Тухайн өгөгдөлд GeneMarker программ ашиглан үр дүнг боловсруулан дүгнэлт гаргав.	2025	16,322.0	16,322.0
11	“Монголын өндөрлөгийн хоёр бөхт тэмээний үүлдэр угсааны генетик онцлог, ашиглалт, өвчин эмгэгээс сэргийлэн эмчлэх судалгаа” ӨМӨЗО-ны Тариалангийн их сургуультай хамтран ажиллах гэрээ	Монгол улсад үржүүлж буй Монгол, Галбын говийн улаан, Ханын хэцийн хүрэн, Төхөм тунгалгийн хүрэн, Ламын гэгээний хурдан хүрэн, Олдохын хүрэн зэрэг 5 үүлдэр, ӨМӨЗО-ны Альшаа, Сүнэд хэмээх 2 үүлдрийн хос бөхт тэмээний генетик онцлогийг митохондрийн зарим ген болон микросателлит маркерууд ашиглан тодорхойлох, түүнчлэн тэмээний эдгээр популяцад зонхилон тохиолдох өвчин эмгэгийг илрүүлэн судлах	Гэрийн хоёр бөхт тэмээний эх шугам нь тодорхой газарзүйн хамааралгүй боловч, генетик олон янз байдал өндөр байгаа нь тодорхойлогдсон.	2024 - 2025		

Биологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дотоодын байгууллагуудын санхүүжилттэй төслүүд						
12	“Эмийн ургамлаас сертуины бүлгийн уургуудыг идэвхжүүлэгч биологийн идэвхт бодис тодорхойлох, тэдгээрийг ашиглан хүнсний бүтээгдэхүүн гаргах судалгаа” АПУ ХК	Энэхүү судалгааны хүрээнд сертуины бүлгийн уургуудыг идэвхжүүлэгч үйлдэл бүхий уламжлалт анагаах ухаанд хэрэглэгддэг эмийн ургамлуудыг илрүүлэх, тэдгээрийн биологийн идэвх, найрлага болон үйлчлэлийн механизмыг судалж, улмаар эдгээр ургамлын гаралтай нэгдлүүдийг хүнсний бүтээгдэхүүнд ашиглах боломж, чиглэл тодорхойлох	Мана хэмээх уламжлалт анагаах ухаанд өргөн хэрэглэгддэг ургамлын үндэсний усан болон спиртэн хандыг бэлтгэв. Спиртэн хандны эсэд үзүүлэх хоруу чанар 2.6 μг/мл концентраци дээр илэрсэн тул цаашдын судалгаанд тохиромжгүй хэмээн үзэж усан хандыг цаашдын судалгаанд ашиглахаар бэлтгэв.	2025 - 2027	119,452.7	72,992.7
13	Эрдэнэтийн цэвэрлэх байгууламжийн бохир усны биологийн цэвэрлэгээнд биологийн идэвхт бичил биетэн ашиглаж, бохирдлыг бууруулах”	Бохир усанд агуулагдах бичил биетний бүлгэмдэл, төрөл зүйлийг тогтоосны үндсэн дээр бохирдуулагчдын эсрэг биоидэвхт бичил биетнийг ашиглан биологи цэвэрлэгээний туршилтуудыг хийж байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд оршино.	Эрдэнэтийн бохир уснаас ялгаж авсан идэвхтэй 16 бактериудыг сонгон усны бохирдол бууруулах лабораторийн туршилтыг хагас үйлдвэрлэлийн төвшинд биореактор угсарч туршихад азот, фосфорын агууламжийг идэвхт лаг бактерийн бүлгэмдэл ашиглан туршсан хувилбар нь Цэвэрлэх байгууламжийн бохир усны биологийн бохирдлыг бууруулахад ашиглах боломжтой болсон төдийгүй идэвхтэй өсгөврийн сантай болж, технологи зүгшрүүлсэн.	2023 - 2025	70,000.0	57,500.0
14	“Biodiversity Priority Plant Propagation Research Service”	Өмнөговь аймгийн Оюутолгой ХК-н уул уурхайн сайт орчмын нэн тэргүүнд хамгаалах шаардлагатай зарим нэн ховор, ховор сөөг, өвслөг ургамлын төлөөлөгчид Грубовын хөөндий, Танамал махирс, Бяцхан навчит яшил болон Монгол шар далан, Монгол буурцгана ургамлуудыг эдийн өсгөврийн аргаар үржүүлэх, генофондыг хамгаалах, цаашид нөхөн сэргээлтэд хэрэглэх боломжийг тодорхойлоход судалгааны зорилго оршино.	Танамал махирсын 2000 гаруй бичил ургамлыг хөрсөнд шилжүүлж өвөлжүүлэхэд хавар сэргэн ургалт 85%-тай байв. Улмаар 1625 бичил суулгац-ыг агротехникийн зааварчилгааны хамт БУҮГ-т хүлээлгэн өгсөн. Монгол шар далан, Монгол буурцгана, Бяцхан навчит яшилийн үрийн ариутгалын горим, скарификаци, тэжээлийн орчны тохиромжтой хувилбарыг тогтоон in vitro өсгөврийн судалгааг амжилттайгаар эхлүүлээд байна.	2024 - 2026	936,849.9	198,772.0

**Биологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

15	“Хөхөлзөхийн говь” гэх газарт биологийн олон янз байдлыг тодорхойлох МАК	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх, тус бүс нутгийн биологийн төрөл зүйлийн нөөц, төлөв байдлыг тодорхойлох.	Хээрийн судалгаагаар 13 зүйлийн хөхтөн, 28 зүйлийн шувуу болон 68 зүйлийн гуурст ургамал бүртгэн хээрийн судалгааг хийж гүйцэтгэсэн. Тус судалгааны тайлан, хээрийн судалгааны явц болон, үр дүнгээр богино хэмжээний танин мэдэхүйн видео контент бэлтгэж, тэмдэглэгдсэн зүйлүүдийн зурагт лавлах номыг 400 хувь хэвлэн өгсөн.	2025	103,108.5	82,486.8
16	Амьтны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх ажлын гэрээ.,	Хэнтий аймгийн Баянмөнх сумын Баянбулаг, Хэрлэн, Дулаан багуудад, Язаар уул, Хар ус, Баянмөнх уул, Хар хөндий, Дулаан уул, Их салхит, Баяндай зэрэг газарт монгол тарвага 81 толгой нутагшуулах.	Сонгосон цэг нутагт 81 толгой тарвагыг сэргээн нутагшуулах, орон нутгийн байгаль хамгаалах чиглэлээр ажилладаг гишүүдэд монгол тарваганы биологийн онцлог, амьдрах орчны талаар болон судалгаа, ажиглалтын багаж хэрэгслийг ашиглах, мэдээлэл цуглуулах, сургалт зохион байгуулах ажлуудыг гүйцэтгэсэн.	2025	64,800.0	64,800.0

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус хүрээлэн нь 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нийт 874,606.8 мянган төгрөгөөр батлуулж, Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хуулийн хугацаанд байршуулсан байна.

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлээр нийт урсгал зардлын санхүүжилттэй 3 нээлттэй тендер зарлаж, худалдан авах ажиллагааны зарыг Төрийн худалдан авах ажиллагааны газрын www.tender.gov.mn цахим хуудсанд байршуулж, худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулсан байна. Үүнд:

- “Лабораторийн хэрэгцээнд нэн шаардлагатай багаж тоног төхөөрөмж худалдан авах” нээлттэй тендерт “Мед импекс интернэшнл” ХХК шалгарч 110,979.0 мянган төгрөгөөр 10 нэр төрлийн үндсэн хөрөнгө худалдаж авсан;
- “Монгол орны археологийн нэн ховор олдворын дээж материалд шинэ үеийн нуклодетийн дараалал тогтоох аргаар /NGS/ генийн дараалал тогтоох, гаплотипийг тогтоох, шинжилгээ, судалгааны ажил” нээлттэй тендерт “Мед Монгол” ХХК шалгарч, 120,000.0 мянган төгрөгөөр гэрээнд тусгагдсан ажлыг 100.0 хувь гүйцэтгэж, гэрээний хэрэгжилтийг бүрэн биелэгдсэн гэж дүгнэсэн;
- “Шавж судлалын /эрвээхэй/ мэдээллийн санг баяжуулах үзмэр эталон бэлтгэх ажил” нээлттэй тендерт “Ц.Одбаяр” шалгарч, 120,000.0 мянган төгрөгөөр гэрээнд тусгагдсан ажлыг 100.0 хувь гүйцэтгэж, гэрээний хэрэгжилтийг бүрэн биелэгдсэн гэж дүгнэсэн байна.

Лабораториудын хэрэгцээнд шаардлагатай жижиг багаж хэрэгсэл худалдан авах 33,200.0 мянган төгрөг, Хээрийн судалгааны ажилд шаардлагатай жижиг багаж, хэрэгсэл худалдан авах 75,000.0 мянган төгрөг, Хүрээлэнгийн албан хэрэгцээнд шаардлагатай электрон бараа

худалдан авах 44,500.0 мянган төгрөг, Лабораториудын судалгааны ажилд шаардлагатай урвалж бодис худалдан авах 99,000.0 мянган төгрөг, Молекул биологийн судалгааны ажилд шаардлагатай урвалж бодис худалдан авах 43,000.0 мянган төгрөг, Хүрээлэнгийн албан хэрэгцээнд шаардлагатай тоног, төхөөрөмж 55,500.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар тус тус сонгон шалгаруулж, худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Биологийн хүрээлэнгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн хүрээлэн, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, цалин хөлс, үндсэн хөрөнгө, нэмэлт төсвийн зарцуулалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ажу мэргэн аудит ХХК-ийн аудитор Д.Наранчимэг, гэрээт аудитор Л.Хонгорзул нар гүйцэтгэж, аудитын чанарын хяналтын менежер Л.Долгорсүрэн, захирал Л.Насанбуян нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Тэгшсүрэн, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Биологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01/12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,326,781.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 43,267.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хүүхдээ асрах чөлөөтэй болон хүрээлэнгийн захиалгаар гадаадад суралцаж байгаа ажилтнуудын сул орон тоонд томилгоо хийхгүй байх, тэтгэмж олголтыг хязгаарлах зэрэг арга хэмжээ авч ажилласнаар батлагдсан төсвөөс цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 171,538.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 31,264.0 мянган төгрөг, тэтгэмж, урамшууллын зардал 3,434.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтээр горим сорил хэрэгжүүлэхэд тус хуулийн хязгаарласан заалтуудтай холбоотой зөрчил илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт **5,175,481.7** мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 128 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 4,561,510.4 мянган төгрөгийн 28 гүйлгээ, 613,971.3 мянган төгрөгийн зарлагын 38 гүйлгээг тус тус хугацаа хоцроож байршуулсан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6-р зүйлийн 6.4.4-т “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй, цахим системд ил тод тавих мэдээллийг хугацаа хоцроож байршуулдаг зөрчлийг таслан зогсоож, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Худалдан авах төлөвлөгөөний дагуу 9 удаагийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл дутуу, тендерийг үнэлэх журмын дагуу маягтуудыг нөхөж үнэлээг хийгээгүй, тендер шалгаруулалтад оролцогчийн санхүүгийн, хүний нөөцийн чадавхыг үнэлэхэд шаардлагатай нотлох баримтууд байхгүй, зарим оролцогч санал болгож буй техникийн тодорхойлолт болон нотлох баримт бичгийг лавлах эх сурвалжийн дагуу ирүүлээгүй байхад шалгаруулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1-д "Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, тендер хянан үзэх, үнэлэх, хяналт тавих, тайлагнах, гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий ажилтан, албан тушаалтан энэ хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, ... үүргийг хүлээнэ", Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалаар батлагдсан "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар"-ын 1.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн гуравдугаар бүлэгт зааснаар тендер хянан үзэх, үнэлэхтэй холбоотой нарийвчилсан харилцаанд энэ аргачлал, зааврыг баримтална" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Худалдан авах ажиллагааны тендерийг хянан үзэх, үнэлэх ажиллагааг Сангийн сайдын баталсан холбогдох аргачлал, зааврын дагуу гүйцэтгээгүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан шалгуурт тус тус нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж авлага, өглөг, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, цалин, орлого, зарлагын данснуудын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд нийт 82,394.9 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 42,119.4 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан, 40,275.5 мянган төгрөгийн 1 зөрчлийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын тайланд тусгасан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад 18,535.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 4,034.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж тус тус бүрэн хэрэгжиж, биелэлт 100.0 хувьтай байна.

Хүснэгт 4 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	18,535.0	1	18,535.0	100.0
Зөвлөмж	3	4,034.0	3	4,034.0	100.0
Нийт дүн	4	22,569.0	4	22,569.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

1. Хүрээлэнгийн он дамжин үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдийн эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнг авч үзэх;
2. Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг сайжруулахтай холбоотой дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:
 - Журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт болон Сангийн яамны finperform.mof.gov.mn сайт дахь маягт хоорондын зөрүүг арилгах.
 - Журмын гуравдугаар хавсралтаар батлагдсан дансны жишиг жагсаалтыг дээрх Сангийн яамны шинэ сайттай уялдуулах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 43,166.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 2,000.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 40,275.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 891.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 43,166.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 101.3 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгчийн 2025.04.04-ний өдрийн 1/122 тоот албан бичгээр ирүүлсэн зөвшөөрлийг зөрчиж, эрдэмтэн нарийн бичгийн даргад 1,100,0 мянган төгрөгийн урамшуулал олгосон, ерөнхий нягтлан бодогчид 900.0 мянган төгрөгийг 1 дүгээр улирлын урамшуулалтай давхардуулж, нийт 2,000.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:", 4.1.6-д "сахилга баттай байх", 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгчийн зөвшөөрлийг зөрчиж олгосон урамшууллыг холбогдох ажилтнуудаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Анхан шатны баримтын бүрдэлгүй 40,275.5 мянган төгрөгийн бараа материалыг зарлагдаж, санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтгүй ажил гүйлгээг бүртгэлд тусгадаг зөрчлийг таслан зогсоох, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөлгүй нэр бүхий аж ахуйн нэгжээс 891.0 мянган төгрөгийн эм урвалж худалдан авсан.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Тусгай зөвшөөрлийг өмчлөлийн хэлбэрээс үл хамааран хуулийн этгээдэд дангаар болон хавсарсан байдлаар энэ хуулийн 7.7-д заасан тусгай зөвшөөрлийн комиссын шийдвэрийг үндэслэн дараах чиглэлээр ... олгоно", 6.1.2-т "эм, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн импортлох-ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн худалдан авахдаа тусгай зөвшөөрөлтэй байгууллагаас худалдан авч байх

2. Бүтэц, орон тоотой холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус хүрээлэнгийн бүтэц орон тоог Шинжлэх ухааны академийн тэргүүлэгчдийн хурлын 2025 оны 04 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд 2025 онд албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 04 дүгээр албан даалгаврын 1.2 дахь заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын удирдлагын бүтэц, орон тооны хуваарилалтыг дахин хянаж, удирдах албан тушаалтны орон тоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Биологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Анхан шатны баримтын бүрдэлгүй 40,275.5 мянган төгрөгийн бараа материалыг зарлагдаж, санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан.	1	40,275.5			1	40,275.5						
2	Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөлгүй нэр бүхий аж ахуйн нэгжээс 891.0 мянган төгрөгийн эм урвалж худалдан авсан	1	891.0					1	891.0				
3	Монгол Улсын ШУА-ийн Ерөнхийлөгчийн 2025.04.04-ний өдрийн 1/122 тоот албан бичгээр ирүүлсэн зөвшөөрлийг зөрчиж эрдэмтэн нарийн бичгийн даргад 1,100,0 мянган төгрөгийн урамшуулал олгосон, ерөнхий нягтлан бодогчид 900.0 мянган төгрөгийг 1 дүгээр улирлын урамшуулалтай давхардуулан олгосон	1	2,000.0	1	2,000.0								
4	Тус хүрээлэнгийн бүтэц орон тоог Шинжлэх ухааны академийн тэргүүлэгчдийн хурлын 2025 оны 04 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд 2025 онд албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.	1	-					1	-				
	Дүн	4	43,166.5	1	2,000.0	1	40,275.5	2	891.0				

Биологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 128 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 4,561,510.4 мянган төгрөгийн 28 гүйлгээ, 613,971.3 мянган төгрөгийн зарлагын 38 гүйлгээг тус тус хугацаа хоцроож байршуулсан.	1	5,175,481.7			1	5,175,481.7		
	Дүн	1	5,175,481.7			1	5,175,481.7		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
2	Худалдан авах төлөвлөгөөний дагуу 9 удаагийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл дутуу, тендерийг үнэлэх журмын дагуу маягтуудыг нөхөж үнэлээг хийгээгүй, тендер шалгаруулалтад оролцогчийн санхүүгийн, хүний нөөцийн чадавхыг үнэлэхэд шаардлагатай нотлох баримтууд байхгүй, зарим оролцогч санал болгож буй техникийн тодорхойлолт болон нотлох баримт бичгийг лавлах эх сурвалжийн дагуу ирүүлээгүй байхад шалгаруулсан байна.	1	-			1	-		
	Дүн	1	-				-		
	Нийт дүн	2	5,175,481.7			1	5,175,481.7		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 57/A0150122

Улаанбаатар хот

САГ-2026/34/НА - СТА - ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгчийн 2025 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 1/122 тоот албан бичгээр ирүүлсэн зөвшөөрлийг зөрчиж эрдэмтэн нарийн бичгийн даргад 1,100,000.00 /нэг сая нэг зуун мянган/ төгрөгийн урамшуулал олгосон, ерөнхий нягтлан бодогчид 900,000.00 /есөн зуун мянган/ төгрөгийг 1 дүгээр улирлын урамшуулалтай давхардуулж, нийт 2,000,000.00 /Хоёр сая/ төгрөгийн урамшуулал олгосон.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:", 4.1.6-д "сахилга баттай байх", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"-д гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь**.

1. Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгчийн зөвшөөрлийг зөрчиж олгосон 2,000,000.00 /Хоёр сая/ төгрөгийг эрдэмтэн нарийн бичгийн дарга Т.Адьяадолгор, нягтлан бодогч А.Алтайсайхан нараар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Биологийн хүрээлэнгийн захирал /Д.Гантулга/-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Л.НАСАНБУЯН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бдга тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Aki\2026\0225\SAГ-27.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 280/АД150122

Улаанбаатар хот

САГ-2026/34/НА-СТА-ТМЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 128 мэдээллээс 2 мэдээллийг, мөн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 4,561,510,400.00 /Дөрвөн тэрбум таван зуун жаран нэгэн сая таван зуун арван мянга дөрвөн зуун/ төгрөгийн 28 гүйлгээ, зарлагын 613,971,300 /зургаан зуун арван гурван сая есөн зуун далан нэгэн мянга гурван зуун/ төгрөгийн 38 гүйлгээг тус тус хугацаа хоцроож байршуулсан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга хүлээн авагчийн нэр" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй, цахим системд ил тод тавих мэдээллийг хугацаа хоцроож байршуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биологийн хүрээлэнгийн захирал /Д.Гантулга/, ахлах нягтлан бодогч /А.Алтайсайхан/ нарт даалгав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
П.ИАНЦАЛДУЛАМ
Л.НАСАНБУЯН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 281/А0150122

Улаанбаатар хот

САГ - 2026/34/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримтын бүрдэлгүй 40,275,527.00 (Дөчин сая хоёр зуун далан таван мянга таван зуун хорин долоон) төгрөгийн бараа материалыг зарлагадаж, санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтгүй ажил гүйлгээг бүртгэлд тусгадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биологийн хүрээлэнгийн захирал /Д.Гантулга/, ахлах нягтлан бодогч /А.Алтайсайхан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Л.НАСАНБУЯН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 282/А0150122

Улаанбаатар хот

САГ-2026/34/НА - СТА - ТИЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах төлөвлөгөөний дагуу 9 удаагийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл дутуу, тендерийг үнэлэх журмын дагуу маягтуудыг нөхөж үнэлээг хийгээгүй, тендер шалгаруулалтад оролцогчийн санхүүгийн, хүний нөөцийн чадавхийг үнэлэхэд шаардлагатай нотлох баримтууд байхгүй, зарим оролцогч санал болгож буй техникийн тодорхойлолт болон нотлох баримт бичгийг лавлах эх сурвалжийн дагуу ирүүлээгүй байхад сонгон шалгаруулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4-т "Захиалагч тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцэх эсэхийг дараах байдлаар хянан үзнэ", 26.4.1-д "энэ хуулийн 15, 16, 17 дугаар зүйлд заасан чадавхын болон туршлагын доод шаардлагыг хангасан байх", 52 дугаар зүйлийн 52.1-д "Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, тендер хянан үзэх, үнэлэх, хяналт тавих, тайлагнах, гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий ажилтан, албан тушаалтан энэ хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, ... үүргийг хүлээнэ", Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалаар батлагдсан "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар"-ын 1.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн гуравдугаар бүлэгт зааснаар тендер хянан үзэх, үнэлэхтэй холбоотой нарийвчилсан харилцаанд энэ аргачлал, зааврыг баримтална" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны тендерийг хянан үзэх, үнэлэх ажиллагааг Сангийн сайдын баталсан холбогдох аргачлал, зааврын дагуу гүйцэтгээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биологийн хүрээлэнгийн захирал /Д.Гантулга/, ахлах нягтлан бодогч /А.Алтайсайхан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
П.НАНЦАЛДУЛАМ
Л.НАСАНБУЯН